


Судрууд болон бошиглогчид бидэнд өөдрөг байх арга замыг зааж өгсөн байдаг.



Жинхэнэ баяр баяслын бүрэн байдал зөвхөн Бурханаар дамжин ирдэг (С ба Г 101: 36-г үзнэ үү). Биднийг Түүн рүү хандах үед бидний сэтгэл зүрх өөрчлөгдөнө.



Бурхан бидний хүн нэг бүрийн амьдралыг адисалдаг (Дуулал 145:9-ийг үзнэ үү). Бид өөрсдийн амьдрал дахь Түүний өршөөлийг ухамсарлан ойлгохыг хичээх ёстой.

Бурханд анхаарлаа төвлөрүүлэх нь ганц удаа хийгээд өнгөрчих зүйл биш юм. Бид долоо хоног бүр ариун ёслолоос зохистой хүртэх зэрэг гэрээнд орж, тэрхүү гэрээгээ үргэлж сахиж байх ёстой.



Бид Нифайн адил судруудад баясаж чадна (2 Нифай 4:15–16). Бурханы болон Түүний бошиглогчдын үгсийг унших нь бидний сэтгэлийг өргөх болно.



Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) биднийг “нэг нэгнийхээ алдаа дутагдлын талаар бус, харин ариун журмын талаар илүү ярьцгааж”, “ариун журам, хичээл зүтгэлийг үнэлж бай” хэмээн уриалсан билээ.⁴